

БАТЛАВ:
УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ - ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
...../Б.САРАНТУЯА/



БАТЛАВ:
"ЭМ СИ ТИ ТИ" ХХК-НИЙ
ЗАХИРАЛ:
...../Б.ОЮУНБИЛЭГ/



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2021 оны 04 сарын 27-ны өдөр

Дугаар-2

Чойр хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны газар"-ын гаргасан 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн №44 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын олгосон 2021 оны 04 сарын 27-ны өдрийн 2 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны газар зүйн мэдээллийн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн О.Батхүү, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, Алтан өргөө цогцолбор, 72-А байрны 26 тоот, 9019001105 улсын бүртгэлийн дугаартай, 5015243 регистрийн дугаартай "Эм Си Ти Ти" ХХК-ний менежер Э.Мөрөн нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Тусгай зөвшөөрлийн дугаар MV-012605. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайгаас жоншны хүдэр худалдан авч боловсруулна.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 60'755 м³/жил

2.2.1. Үйлдвэрлэлд: 57'965 м³/жил

2.2.2 Унд ахуйд: 2'160 м³/жил

2.2.3 Зам талбайн тоосжилтонд: 630 м³/жил

2.3. Усны эх үүсвэр: Ус хангамжийн 3ш өрөмдмөл худагтай.

2.4.1. Байршил: Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Тэвшийн хөндийд байрладаг.

2.4.2. Солбицол:	1-р худаг х-108 26 96,5	у-46 16 30,6	ундарга 5л/с
	2-р худаг х-108 27 14,5	у-46 16 0,55	ундарга 5л/с
	3-р худаг х-108 26 88,3	у-46 16 18,9	ундарга 5л/с

2.4.3. Барилга байгууламж: Хаягдлын сан 262'800 м³ багтаамжтай геомембран доторлогоотой, баяжуулах үйлдвэрээс баруун урд зүгт 85м зайд байрлана.

2.4.4. Тоног төхөөрөмжийн нэр, марк: Худаг тус бүр 200-QJ-55KW маркын насостай.

2.5. Хаягдал ус: Унд ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг бохирын цооногт хуримтлуулан соруулж орон нутгийн цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг.

Хаях цэгийн байршил:

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана. /Биохимийн шинжилгээ хийлгээгүй./

2.7. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуур: худаг бүр TLT, ДН-80 маркийн 3 ширхэг тоолууртай

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу үйлдвэрийн ажилчдын унд ахуйн хэрэгцээнд хэрэглэх $2'160 \text{ м}^3$ усыг төлбөрөөс чөлөөлнө.

Хайлуур жонш баяжуулах зориулалтаар нөхөн сэлбэлтээр авч ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3,700 \text{ төг/м}^3 \times 0,2 \times 1,6 = 1,184 \text{ төг/м}^3$$

$3,700 \text{ төг/м}^3$ Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:

(20%)-326-р тогтоолын 7(б) газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээ.

1,6- Хайлуур жонш баяжуулах зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$57'965 \text{ м}^3 \times 1'184.0 \text{ төг/м}^3 = 68'630'560.0 \text{ төгрөг}$$

Зам талбайн тоосжилт дарахад ашиглах газрын доорх усны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3,700 \text{ төг/м}^3 \times 0,2 \times 0,25 = 185,0 \text{ төг/м}^3$$

$3,700 \text{ төг/м}^3$ Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:

(20%)-326-р тогтоолын 4 заасан авто замын зориулалтаар тооцох газрын доорх усны хувь хэмжээ.

0,25- авто замын зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$630 \text{ м}^3 \times 185.0 \text{ төг/м}^3 = 116'550.0 \text{ төгрөг}$$

Нийт төлбөр: $68'630'560.0 + 116'550.0 = 68'747'110.0$ төгрөг /Жаран найман сая долоон зуун дөчин долоон мянга нэг зуун арван төгрөг/-ийг Говьсүмбэр аймгийн төрийн сан банкны 100'220000944 тоот дансанд төвлөрүүлнэ.

Усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн мэдээ тайланг бүтэн жилээр гаргаж ирүүлнэ.

Жич: Ус ашигласны төлбөрийг усны эх үүсвэрт байрлуулсан усны тоолуурын заалтаар, Говьсүмбэр аймгийн татварын буюу байгаль орчны хяналтын улсын байцаагч үйлдвэрийн төлөөллийг байлцуулан тоолуурын заалтыг сар бүрийн 25-ны дотор авах 30-ны дотор төлбөрийг төлнө.

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Ус ашиглуулагч нь Усны тухай хуулийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.2.1. Усны тухай хуулийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх.

3.2.2. Усны тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг сав газрын захиргаанд гаргаж өгнө.

3.2.3. Ажилчдын ундны усыг стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.

3.2.4. Ус ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд сав газрын захиргааны холбогдох мэргэжилтнийг дуудаж газар дээр нь шийдвэрлэж байх.

3.2.5. Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.2.6. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн бол "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.2.7. Усны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2016 оны 07 сарын 07-ны өдрийн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын А/218 тоот тушаалаар батлагдсан усны хяналт шинжилгээ аудит хийлгэх.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны газар зүйн мэдээллийн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн

...../О.Батхүү/

Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, 12-байр 46 тоот.

Харилцах утас: 7054-3598

Факс: 7054-3599

Ус ашиглагчийг төлөөлж:

"Эм Си Ти Ти" ХХК-ний менежер

...../Э.Мөрөн/

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, Алтан

өргөө цогцолбор, 72-А байрны 26

тоот

Харилцах утас: 99998208